



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/437

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.“б”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 03/07 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хүрээнд “Баянтээг түлш” ОНӨХХК-д нэн шаардагатай тоног төхөөрөмж, бараа материалыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх тоног төхөөрөмж, бараа материалын зардалд шаардагдах 169,500,000 (нэг зуун жаран есөн сая таван зуун мянга) төгрөгийг агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Хавсралтад тусгагдсан тоног төхөөрөмж, бараа материал худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (З.Балданням), “Баянтээг түлш” ОНӨХХК-ийн гүйцэтгэх захирал (Д.Азбилэг) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100929

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2021 оны 09  
дугаар сарын 16-ны өдрийн 1/137 дугаар  
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Тоног төхөөрөмж, бараа материал	Төсөвт өртөг
1	Ажилчдын амрах байр, хоолны газар, халуун ус, ариун цэврийн байгууламжийг шийдвэрлэх. (зөөврийн сууц авах)	65,500,000
2	Түлшний хэвлэгч бул нэмэлтээр суурилуулах	35,000,000
3	Цардуул бутлагч худалдаж авч, суурилуулах	20,000,000
4	Үйлдвэрийн агааржуулалтын асуудлыг шийдвэрлэх	18,000,000
5	Түлш савлах уутны зардал	10,000,000
6	Эхний ээлжийн 500 өрхөд утаа мэдрэгч суурилуулах	6,000,000
7	Улаан буудайн үнэ, тээврийн зардал	15,000,000
	НИЙТ ДҮН	169,500,000

-oOo-

